

МОНГОЛЫН ХОШИН ШОГ НИЙТЛЭЛИЙН  
УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ

Н.Мөнхзориг\*

\* "Идэр" дээд сургууль, Монгол хэл, Сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч, магистр, докторант

**Түлхүүр үг:** шог хошин нийтлэлийн уламжлал, илчлэн шүүмжилсэн нийтлэл, хошин шог нийтлэл, "Хүмүүжил жигшил" сэтгүүл, "Матар" сэтгүүл, "Тоншуул" сэтгүүл, хошин шог нийтлэлийн сэдэв, бичлэгийн төрөл зүйл, хошин шог нийтлэлчид.

**М**онголын хошин шог нийтлэл эртний түүхэн уламжлалтай. Манжийн дарлалын үед харгис хэрцгий баяд ноёдын балмад догшин, шударга бус байдлыг нэвт шүүмжилж ирсэн үеэс эхтэй байна. Ялангуяа XIX зууны сүүл үеэс дарлан мөлжигч ихэс дээдэс, эрх ямбатнуудын хүний үнэргүй, эрээ цээргүй авирыг эрс шулуун эсэргүүцэн шүүмжилж, элэглэн шоглож, эерүүлэн егөөдөж, далд санаагаар хатгаж, хошигнон ёгтолсон бүтээл хийгээд түүнийг зохиогчид мэдэгдэхүйц олширч иржээ. Тухайлбал: Хатгины Гэндэн Мэйрэнгийн зохиосон «Хав, муур, хулгана гурвын үлгэр»-т ихэс лам нар, ноёдын хамжлага, харьяат нараа булаалдсан явдлыг үзүүлсэн бол, Ордосын Данзанванжилын шүлэгт мөн

феодал ангийн ялзарсан байдлыг хурц ширүүнээр шүүмжилжээ. Энэ үед ардын шог яруу найргийн мастер хуульч Сандаг «Үг» зохиолоороо нэрд гарч, амьтны дүрээр тухайн үеийн ард түмний хүнд бэрх амьдрал, харгис ноёд, лам нарын хатуу чанга ёс дэглэм, хахуульч шунахай байдлыг шоглон шүүмжилж байв<sup>1</sup>.

XIX зууны Монголын утга зохиолын сод төлөөлөгч, бичгийн их хүн В.Инжинаши нэгдүгээрт: Манжийн ноёрхлыг эсэргүүцсэн, хоёрдугаарт: Монголын феодалуудын сул доройг шүүмжилсэн, гуравдугаарт: шашин, лам нарын ёс суртахууны дутагдлыг илчилсэн «Үзэл санааг нь эс мэдэв», «Чулуун дэрийн шүүмжлэл», «Эрдэмтнийг занаж, чадалтанд хорсогчид», «Номчийн хуурмаг», «Хөх судар» романы оршил болох «Товчит тольт» зэрэг эссе, «Хөдөөгийн өвгөний оршил» хэмээх шүүмжлэлт тэмдэглэл гэх мэт бүтээл туурвижээ. Мөн зууны бичиг эрдмийн их хүмүүс болох гүн сэтгэгч Агваанбалдан, Л.Агваанхайдав, догшин ноён хутагт Д.Равжаа, шүлэгч Хишигбат, Ашиг Занги, солиот Шагдар нарын ардын билэгтнүүд

харгис хэрцгий баяд ноёд, ихэс дээдэстэй зүйл бүрээр мөчөөрхөн тэмцэж, хурц ширүүнээр шоглон шүүмжилж байв. Ер нь Монголын хошин шог нийтлэл монгол ардын аман зохиол, ардын шог хошин яриа, ард олны дунд ихэд дэлгэрсэн бадарчны үлгэр, Далан худалчийн үлгэр, уран цэцэн үгтэй «Бэлэн Сэнгэ»-нүүд, мөн адгуус араатан, амьгүй зүйлээр төлөөлүүлэн хүншүүлж, тэдний хоорондын яриа, өчих өчлөөр нийгмийн амьдралд хандаж, феодал ангийн баяд ноёдын харгис дээрэнгүй, ховдог шунахай явдлыг хурцаар нэвт шүүмжилсэн «Үг» зохиол гэх мэт шог хошин зохиолын арвин их баялаг өв санг шинэ цаг үед өвлөн авч, баяжуулан хөгжүүлжээ. Эдгээр шог хошин зүйл нь аль ч нийгмийн үед амьдрал, нийгэмд бодитой оршин байгаа дутагдлыг зад шүүмжилж, дайрч доромжилж, элэглэн шоолж, ёгтлон егөөдөж, даажигнан дамшиглаж, зөрүүлэн хатгаж, өөлөн баалж ирсэн байна.

XIX зууны үеийн болон XX зууны эхний хагасын ном эрдэмд нэвтэрхий гэгээрэн гүнд нь орсон бичгийн их хүмүүс В.Инжинаши, Агваанбалдан, Л.Агваанхайдав, Д.Равжаа, хуульч Сандаг, шүлэгч Хишигбат, Ж.Цэвээн, Д.Бодоо, Д.Нацагдорж, С.Буяннэмэх, Г.Навааннамжил, Ц.Дамбадорж, Д.Цэвэгмэд, Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен, Л.Бадарч,

Ц.Цэдэнжав, Ч.Ойдов, Л.Ванган нарын нийгэм, цаг үеэ шүүмжилсэн хурц дайчин бүтээлүүд Монголын хошин шог нийтлэл хөгжин төлөвшихөд онцгой үүрэг гүйцэтгэжээ. Ингэхдээ хувьсгалаас өмнөх үеийн бичгийн их хүмүүс тухайн нийгэмдээ нийцүүлэн, амьтдаар төлөөлүүлэх, юмыг хүнчлэх хэлбэрийг ашиглан зөөлрүүлсэн, далд утгаар ёгтлон шоглох, хошигнон даажигнах аргыг хэрэглэж байсан бол хувьсгал ялснаас хойшх үеийн бичгийн хүмүүс амьдрал, нийгэмд оршиж байгаа дутагдлыг ил шүүмжлэх болж иржээ. Ер нь Монголын сэтгүүл зүйн эхэн үеийн тогтмол хэвлэлүүдийн ихэнх нь шог хошин шинжтэй шүүмжлэлт нийтлэлийг түлхүү тусгаж байв. Жи-

шээлэхэд: монголчууд өөрсдөө гаргасан анхны тогтмол хэвлэл «Шинэ толь хэмээх бичиг», удаах хэвлэл болох «Нийслэл хүрээний сонин бичиг»-т булаан эзлэгчдийн харгис хэрцгий байдал, засгийн газрын том түшмэлүүдийн авлигач, бурангуй явдал, харийнхантай сүлбэлдсэн арчаагүй байдал зэргийг хайр найргүй шүүмжилж, мөн ард олны хүчин мөхөс сул дорой, соёл боловсролгүй, улс орон, эрх чөлөө, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, эрх ашгийнхаа төлөө нэгэн санаа, нэгэн хүчээр тэмцэж чадахгүй байгаа явдал,

«

*Хувьсгалаас өмнөх үеийн бичгийн их хүмүүс тухайн нийгэмдээ нийцүүлэн, амьтдаар төлөөлүүлэх, юмыг хүнчлэх хэлбэрийг ашиглан зөөлрүүлсэн, далд утгаар ёгтлон шоглох, хошигнон даажигнах аргыг хэрэглэж байсан бол хувьсгал ялснаас хойшх үеийн бичгийн хүмүүс амьдрал, нийгэмд оршиж байгаа дутагдлыг ил шүүмжлэх болж иржээ.*

»

Манжийн дарлалд хоёр зуу гаруй жил дарлагдан зовсон Монголын ард түмний үндэсний ухамсрыг сэргээх асуудал зэргийг хөндөн тогтмол сануулга, анхааруулгын шинжтэй нийтлэл бичиж байв.

«Шинэ толь хэмээх бичиг» сониньхон илт сөрөг байр суурьтай байжээ. Сонин засгийн зарим эрхтэн дархтны улс орноо боддоггүй, нэр төр, албан тушаал, хувийн жаргалыг эрхэмлэсэн арчаагүй явдлыг нэр заан шүүмжилдэг байв. Ардчилсан өөрчлөлт хийх санаагаа илэрхийлэхдээ хар, шар феодалуудын зөрчлийг эвтэйхэн ашиглаж, хурц шүүмжлэлээ эерүүлэх аргатай хослуулан уян хатан өрнүүлдэг байжээ<sup>2</sup>. «Шинэ толь хэмээх бичиг»-ийн цаг үеэ тусгасан шүүмжлэлт нийтлэлүүд нь шог, хошин гэсэн нэр тодотголтгүй байгаа боловч хошин шог нийтлэлийн шинж, элемент, өнгө аясыг нэвт шингээсэн байна.

**М**онголчууд өөрсдөө гаргасан хоёр дахь тогтмол хэвлэл «Нийслэл хүрээний сонин бичиг» сонинь хувьд мөн л Монгол орны гадаад, дотоод байдал, улс төрийн амьдрал, аж ахуй, соёлын асуудал, урлаг утга зохиол, ёс суртахуун, шударга бус татвар гувчуур, боолчлолын сэдвийг өргөн тусгадаг, нэг ёсны «Шинэ толь хэмээх бичиг»-ийн дэвшилтэт үзэл санаа, шударга эх оронч шүүмжлэлийг үргэлжлүүлэн гүнзгийрүүлсэн, илүү туршлагажсан, илүү даацтай нийтлэлтэй, залгамжлагч сонин байсан төдийгүй ард түмний эрх ашгийг хамгаалж, Монголын феодалын байгууллын хоцрогдол, ихэс дээдэс, ноёд түшмэдийн харгис хэрцгий явдлыг хурц шүүмжилж, улс

үндэстнийхээ тусгаар тогтнолыг хамгаалан бэхжүүлэх, харийн түрэмгийллийн эсрэг тууштай тэмцэх чиглэлийг баттай барьсан эх оронч дэвшилтэт ардчилсан хэвлэл байв.

«Нийслэл хүрээний сонин бичиг»-ийн үнэт уламжлалын нэг нь илчлэн шүүмжлэх чиглэлийг сонинь нийтлэлд ухаалаг бөгөөд уян хатан аргаар төлөвшүүлсэн явдал мөн.<sup>3</sup> Уг сонин «Шүүмжлэл», «Эсэргүүцэл» зэрэг булан хөтөлж, түүндээ хурц шүүмжлэлт нийтлэлүүдээ бичиж байлаа.

Хувьсгалын эхэн үеийн хэвлэлүүдэд ч хуучин нийгмийн үзэгдлийг хайр найргүй шүүмжилсэн шогууд өргөн нийтлэгдэж байжээ. Энэ ч учраас 1921-1940-өөд оны нийтлэлийг бүхэлдээ илчлэн шүүмжлэгч шинжтэй байсан гэж үзэх нь бий. 1921 оны 7-р сарын 19-нөөс гарч эхэлсэн, «Уриа» сонин гэхэд илчлэн шүүмжилсэн шинжтэй нийтлэлүүдээ ихэвчлэн «Шүүмжлэл» булангийн дор нийтэлдэг, дайчин нийтлэлтэй хэвлэл байв. Нийтлэлийнхээ үндсэн зорилгыг тодорхойлохдоо: «Манай сонин намын үзэл суртлыг өргөн дэлгэрүүлж, ард түмний улс төрийн талаар хүмүүжүүлэх чухал зэвсэг болж, умартсаныг сануулж, олтгойрсныг залруулж, дарлагдаж зүдрэгчдийг хамгаалж, харгис хуурмаг явдалтай эвлэршгүй тэмцэж, улс орны ажил үйлсийг сайжруулан мандуулахад тусална» гэжээ. Хуучин дэглэмийг баримтлан, илд далд эсэргүүцэл гаргасан ноёд түшмэдийг нэр заан шүүмжилдэг байсан нь тухайн сонинь хамгийн зоригтой бөгөөд хамгийн хүчтэй илчлэн шүүмжилсэн нийтлэл болж байсан байна.

1922 оны 6-р сарын 22-ноос хэвлэгдэж эхэлсэн «Хураангуй сэтгүүл» сонин хувьд орон нутгийн ажил амьдрал, төрийн яамдын түшмэл, бичээч нарын ажлын хариуцлага, сахилга сул байгааг, гаалийн ажилтан, хязгаарын сайд нарын дотор танил тал харах, хээл хахууль авах, ёс суртахуунаар доройтох, хуулийг завхруулах явдал гарч байсныг ёжтой хурц үгээр элэглэн шүүмжилж байв. 1920-30-аад оны үед гарч байсан «Нийслэлийн шинэ сонин» (1923-1924), «Ардын эрх» (1924-1925), «Ардын үндэсний эрх» (1932-1941) зэрэг хэвлэл ч мөн адил «Шүүмжлэл» гэсэн тогтмол булан хөтөлж, түүндээ төв, орон нутгийн байгууллагын ажилтнуудын хариуцлага, сахилга батгүй байдал, хүрээний цагдаа нарын хариуцлагагүй явдлууд, албаны ажилд алагчлан бялдуучлах, хээл хахууль авах явдал үзэгдсээр байгаа зэргийг шүүмжилж байжээ.

Энэ бүхнээс эх ундаргаа аван манай хошин шог нийтлэл цэцэглэн хөгжжээ. 1934 онд хуралдсан намын IX их хурлаас феодалын нийгмийн үлдэгдэлтэй хийх тэмцлийг хүчтэй болгохыг заасны дагуу 1935 оны 11-р сард нийгэм-улс төрийн шог сэтгүүл «Хүмүүжил жигшил»-ийг гаргах болсон нь манай хэвлэлийн бичлэгийн шог хошин зүйлийн хөгжилд шинэ бололцоог нээж өгсөн байна. Энэ хугацаанд уг сэтгүүл «Хурц дөл», «Матар», «Тоншуул» гэх мэт нэрээр гарч, нийтлэлийн агуулга, дайчин чанараар нийгмийн эрх ашгийг туйлбартай хамгаалагч, цэцэн шүүмжлэгч байсаар иржээ. Ардын хувьсгалын эхний жилүүдийн хэвлэлд сэтгүүлч Г.Навааннам-

жилын буй болгосон «Бядан явагч бялзуухай миний өгүүлэл» хэмээх шог хошин нийтлэлийн булан манай хэвлэлүүдэд нийтлэлийн уламжлалт хэлбэр болж саяхан болтол хэрэглэгдэж байв. Дээрх буланд тогтмол бичигчид нь манай ахмад зохиолч Ц.Дамдинсүрэн, Д.Нацагдорж, Ц.Цэдэнжав, Д.Цэвэгмэд нар байв. Сэтгүүлч Г.Навааннамжил «Бядан явагч бялзуухай миний өгүүлэл» нэрийн дор бичиж байсан шог хошин бичлэгтээ тодорхой нэр хаягтай, хурц дайчин шүүмжлэл бичиж байсан нь их ач холбогдолтой юм<sup>4</sup>.

### 1. «Матар» сэтгүүлийн хошин шог нийтлэлийн хөгжил төлөвшил

«Хүмүүжил жигшил» сэтгүүл нь манай хошин шог хэвлэлийн эхлэлийг тавьсан юм. Монголын хошин шог нийтлэлийн түүхийг эхлүүлсэн «Хүмүүжил жигшил» сэтгүүл 1935 оны 11-р сараас 1942 он хүртэл «Хурц дөл» нэрээр, 1942 оны 1-р сараас 1960 он хүртэл «Матар» нэрээр тогтмол гарч байжээ.

1942 оны 1-р сард анхны дугаар нь гарсан «Матар» сэтгүүл бол Монголын хошин шог нийтлэлийн хөгжилд чухал хувь нэмэр оруулсан түүхэн тогтмол хэвлэл мөн. Ер нь 1913-1920, 1920-1940-өөд оны үеийн манай тогтмол хэвлэлүүдийн нийтлэл нь ерөнхийдөө илчлэн шүүмжилсэн шинжтэй боловч яг хошин шог нийтлэлийн төрөл зүйл багахан байв. Гэхдээ энэ үеийн хэвлэлүүдийн ихэнх нь «Шүүмжлэл» гэсэн тогтмол булан хөтөлж, түүндээ цаг үеэ шүүмжлэн шоглосон нийтлэлийн буухиаг таслалгүй үргэлжлүүлж ирснийг тэмдэглэх нь зүйтэй.

Харин хошин шог нийтлэл жинхэнэ утгаараа «Хүмүүжил жигшил» сэтгүүлээр эхэлж, «Матар» сэтгүүлээр үргэлжлэн хөгжжээ. Сар тутмын «Матар» сэтгүүл 1942-1945 он хүртэл монгол бичгээр, 1946 оноос хойш кирилл үсгээр гарч байлаа. «Үнэн» сонины газраас эрхлэн гаргаж байсан «Матар» сэтгүүлийн нийтлэлийн гол төрөл, зүйл нь шог нийтлэл (шог өгүүлэл), шог мэдээ, шог шүлэг, жижиг явган шог, хошин зүйр үг, шог үзэгдэл, ардын шог үг, шог үлгэр, албаны хошигнол, хошин оньсого, шог яриа, шог дуу, ёгт үлгэр, үлгэр байв. Харин шог найрууллын хувьд 1940-өөд оны сүүл, 1950-иад оны эхэн үеэс «Матар» сэтгүүлд нийтлэгдэж эхэлжээ.

«Матар» сэтгүүлийн эхний дугааруудад хошин шог гэж нэрлэхээргүй энгийн нийтлэлүүд ч олон байна. Гэхдээ ийм энгийн нийтлэлүүд зөвхөн 1942, 1943 оны дугааруудад цөөхөн тооны үзэгдэж байсныг хэлэх нь зүйтэй. Харин 1943 оны сүүл, 1944 оны эхний дугааруудаас эхлэн «Матар» сэтгүүлийн хошин шог нийтлэл нэлээд зүгширч төлөвшиж эхэлсэн нь ажиглагддаг.

Сэтгүүлийн эхний жилүүдэд гарч байсан дугааруудад Да-гийн су юм уу, Да-гийн сурвалжлага, Го-гийн сурвалжлага, У-гийн Су гэх мэт нэрийг эс тооцвол бараг зохиогчийн нэрийг тавьдаггүй байв. Гэхдээ цөөхөн тооны тогтмол бичигчид нь нэрээрээ бүтээлээ гаргадаг байлаа. Харин 1940 оны сүүлчээс эхлэн зохиогч бүр нэрээ тавьдаг болжээ.

Сэтгүүлийн хошин шог нийтлэлийн нэг онцлог нь өгүүлэх гэж байгаа зүйлийнхээ тухай эхэлж дурдаад, дараагаар нь тодорхой баримт, нэр устай,

аймаг, сум, харьяалалтай уг асуудлаа бичдэг байсан явдал мөн.

«Матар» сэтгүүлийн эхний дугааруудын бас нэг онцлог гэвэл ихэнх материал нь идэвхтэн бичигчдийн захидлаар бүтдэг байв. Идэвхтэн бичигчдийн захидал нь сэтгүүлийн нийтлэлийн нэлээд идэвхтэй хэсгийг бүрдүүлж байжээ.

«Матар» сэтгүүлийн нийтлэлийн агуулгыг илэрхийлсэн шог зургууд нэлээд анхаарал татдаг. «Матар» сэтгүүлийн тайлбартай шог зураг нь ихэнхдээ хөдөлмөрийн хүний дутагдал, олон нийтийн ажлыг цалгардуулж байгааг шүүмжилсэн сэдэвтэй байна. Сэтгүүлийн шог зурагт хоёр давуу тал ажиглагддаг. Нэгдүгээрт, тухайн нийгмийн хөгжилд тодорхой хэмжээгээр саад болох зүйлийг шүүмжилж байв. Хоёрдугаарт, тэр шүүмжлэлд өртөгч нь тодорхой нэр ус, аймаг сумын харьяалалтай албан тушаалтан байдаг. Уг зургуудыг тухайн үеийн зураг урлалын газраас зурдаг байсан ба энэ зурмал зургууд «Матар» сэтгүүлийн хошин шог нийтлэлийн агуулгыг бүрэн илэрхийлж чадаж байснаараа давуу талтай юм.

«Матар» сэтгүүлийн нийтлэл нь ерөнхийдөө дараах сэдвээр бичигдэж байв. Гитлер тэргүүтэй харгис хэрцгий фашизмын дэглэмийг эсэргүүцсэн, албан ажил цалгардуулдаг, хариуцлагагүй албан тушаалтан, ардын шинэ сургуулийн шинэ үсгийн багш, сурагчдыг шүүмжилсэн, архичид, хулгайч, завшигчид, залилан мэхлэгч луйварчид, муу малчдыг элэглэсэн, харгис этгээдийг жигшин зэвүүцсэн, хөдөлмөрийн шинэ хүний алдаа төөрөгдөл, шинэ цаг үеийн

хөгжилд саад бологчид, бохир заваан байдлыг шоглосон, хариуцлагагүй эмч нар, завхай явдалтныг шүүмжилсэн нийтлэл давамгайлж байв.

«Матар» сэтгүүлийн эхний жилүүдийн дугааруудад идэвхтэн бичигчдийн материал зонхилж байсан бол 1940-өөд оны дунд үеэс тогтмол бүтээлээ нийтлүүлдэг мэргэжлийн төвшний хошин шог зүйл бичигчид бий болжээ. «Матар» сэтгүүлийн тогтмол нийтлэлчид нь Л.Бадарч, Ц.Цэдэнжав, Ш.Жамбалсүрэн, Д.Даржаа, Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен, Х.Пэрлээ, Б.Бааст, Б.Авирмэд нар байв. Эдгээрээс Л.Бадарч, Ц.Цэдэнжав, Ш.Жамбалсүрэн нарын нийтлэлүүд сэтгүүлийн сүүлийн жилүүдийн нийтлэлийн гол байрыг эзэлдэг.

«Матар» сэтгүүл бол Монголын хошин шог нийтлэл хөгжихөд чухал нөлөө үзүүлсэн түүхэн хэвлэл мөн.

## 2. «Хүмүүжил жигшил» сэтгүүлийн хошин шог нийтлэлийн хөгжил төлөвшил

Монголын хошин шог нийтлэлийн түүхийг эхлүүлсэн «Хүмүүжил жигшил» сэтгүүл 1961 оны 1-р сараас 1965 оны 12-р сар хүртэл хуучин нэрээрээ гарч байжээ. Энэ үеэс «Хүмүүжил жигшил»-ийн халаг авсан сэтгүүл бол «Тоншуул» сэтгүүл билээ. 1961-1965 онд «Хүмүүжил жигшил»-ийг «Үнэн» сонины газраас эрхлэн гаргаж байлаа. «Хүмүүжил жигшил» сэтгүүл нь жилд тогтмол 12 дугаар гаргадаг «Матар» сэтгүүлийн нэг адил сар тутмын сэтгүүл байв. «Хүмүүжил жигшил» сэтгүүлийн нийтлэл нь ерөнхийдөө «Матар» сэтгүүлийн нийтлэлийн хэв маягийг үргэлжлүүлсэн хэлбэр байлаа.

«Хүмүүжил жигшил» сэтгүүлийн шог хошин нийтлэлийн гол төрөл зүйл нь шог өгүүлэл, шог найруулал, шог мэдээ, шог яриа, шог өгүүлэл, бяцхан шог, шүүмжлэлт хошин сурвалжлага, хошин яриа, шог дуу, ёгт үлгэр, шог шүлэг, хошин туурь, кино үлгэр зэрэг бичлэгийн төрөл зүйл байв.

Эдгээр бичлэгийн төрөл зүйлээс уг сэтгүүлд хамгийн ихээр нийтлэгдэж байсан зүйл бол шог найруулал юм. Ер нь «Хүмүүжил жигшил» сэтгүүлийн 1964, 1965 оны дугааруудын нийт материалын бараг тавин хувь нь шог найруулал байна. Мөн «Хүмүүжил жигшил» сэтгүүлд уран зохиолын богино зүйл болох өгүүллэг олноороо нийтлэгддэг байв.

«Хүмүүжил жигшил» сэтгүүлийн нийтлэл нь сэдвийн хувьд ерөнхийдөө албан ажил цалгардуулдаг, хариуцлагагүй албан тушаалтан, хүнд сурталтан, завшигчид, залилан мэхлэгч луйварчдыг шүүмжилсэн, хөдөлмөр ажлаас зугтан, баяр цэнгэл хөөгчид, залхуучууд, хоосон цэцэрхэгчид, нийгмийн хөгжлөөс хоцрогчдыг шоглосон, гэр бүлийн хүчирхийлэгчдийг жигшин шүүмжилсэн, хүн чанараа гээгчдийг элэглэж байв.

«Хүмүүжил жигшил» сэтгүүлийн хошин шог нийтлэлийн тогтмол бичигчид нь Даг.Жамъяан, Д.Баянбилэг, Н.Иштавхай, Б.Бааст, Н.Цэвэгмэд, Д.Гармаа, М.Гүрсэд, Л.Лодоншарав, Г.Жамъяандорж, Ч.Ойдов, Ё.Мийяа нар юм. Тэднээс Даг.Жамъяан, Н.Иштавхай, Б.Бааст, Н.Цэвэгмэд, Д.Гармаа, М.Гүрсэд, Л.Лодоншарав нарын хошин шог нийтлэл «Хүмүүжил жигшил» -ийн гол ноён нуруу болж байв.

«Хүмүүжил жигшил» сэтгүүл бол манай хошин шог нийтлэлийн бас нэгэн түүхэн тогтмол хэвлэл билээ.

### 3. «Тоншуул» сэтгүүлийн хошин шог нийтлэлийн хөгжил, төлөвшил

Монголын хошин шог нийтлэлийн түүхийг дангаараа 40-өөд жил буюу хамгийн олон жил хөтөлсөн, одоо ч үр хөврөл нь тасраагүй байгаа түүхэн хэвлэл бол «Тоншуул» сэтгүүл билээ. «Тоншуул» сэтгүүл бол 1966 оноос завсартай 40 гаруй жил гарахдаа социализм байгуулахад саад бологчдыг ч хорон үгээр хатгаж, ардчиллын арван хэдэн жилд ам хамхин суулгүй уран хошин үгээр шоглож ирсэн арвин баялаг түүхтэй хэвлэл мөн.

Улс төр, уран сайхны хошин шог сэтгүүл «Тоншуул» нь «Инээд байгаа газар эрүүл нийгэм оршино» гэсэн уриатайгаар дутагдалтай нэг насаараа тэмцсэн хэвлэл билээ.

«Тоншуул» сэтгүүл 1990-ээд оны дунд үеэс түр завсарласан ч 2000 он гараад дахин хурц дайчин шог хошин нийтлэлийнхээ буухиаг үргэлжлүүлж, Монголын цэцэн үгтэй хошин шогчид нийгэм-улс төр, эдийн засгийн хүндхэн тохироотой энэ үед үзгээ тавин, үгээ хэлэлгүй зүгээр суухгүй байна.

1970-1980-аад оны үеийн «Тоншуул» сэтгүүлийн хошин шог нийтлэл ерөнхийдөө тэр үеийн Монгол орны улс төр, эдийн засаг, олон нийтийн оюун санааны хөгжил дэвшлийн зогсонги царцанги байдал, нийгэм дэх хий хоосон дүрэм-дэж хуралдсан хүйтэн цэвдэг уур амьсгал, МАХН гэсэн улс төрийн цорын ганц хүчний үзэл сурталжсан, намчирх-

сан хөндий хуурай, үзэл номлол, соёрхол хүндэтгэлийн хишигт бялуурсан удирдлагууд, улс төрийн ганц хүчний дураараа авирлалт, удирдах албан тушаалтнуудын ихэмсэг, дээрэнгүй, даргамсуу, «тэг ингэ» гэж тушаадаг, хуулиар, улсын ажлаар далайлган сүрдүүлдэг, хатуу донгоддог, цалингийн хувиар торгодог, «хий» гэж үүрэгддэг зэрэг явдлыг, нийгэм олноороо хөдөлмөр ажлаас залхууран зөвхөн бэлэнчлэх сэтгэлгээнд автаж байгааг, хөдөлмөрчин олон зөвхөн үүрэг хүлээж, тушаал заавар даалгавар биелүүлэн, нийтээрээ адилхан сэтгэх сэтгэлгээний баригдмал байдалд орж байгааг, төлөвлөгөө биелүүлэхийн төлөө утга учиргүй амьдралаас тасархай тэмцэл, өмч хөрөнгөтэй холбоотой үзэл бодлын ялзрал, захиргаадах арга, үзэл сурталжсан сэтгэлгээг, цаас төлөвлөгөө журам заавар, хуралдаан зөвлөгөөнд дулдуйдаж хэвшсэнийг, ажил хөдөлмөр, ахан дүүс дотроо хүртэл өөгүй тунгалаг амьдарч байгаа мэтээр сэтгэгцээн бие биеэ, бүр өөрсдийгөө хууран шар нар, бор хоногийг аргацаан өнгөрүүлэх болсон ядмаг сэтгэлгээг хайр найргүй шүүмжилж, хошигнон егөөдөж, элэглэн наргисан шинжтэй байна. Эдгээр нь 1970-1980-аад оны үеийн манай хошин шог нийтлэлийн үндсэн сэдэв байв.

«Тоншуул» сэтгүүлийн хошин шог нийтлэл нь эхэн үедээ бичлэгийн төрөл зүйлийн хувьд шог найруулал давамгайлсан, цөөхөн тооны бичлэгийн зүйлээр хязгаарлагдаж байв.

Харин 1990-ээд он гарснаар манай хошин шог нийтлэлийн бичлэгийн төрөл зүйл, тусгах сэдвийн хувьд цоо шинэ

эрин золгов. Тухайлбал, орчин үеийн «Тоншуул» сэтгүүлийн хошин шог нийтлэл нь хошин өгүүлэл, шог өгүүллэг, хошин мэдээ, шог найруулал, егөөдөл, хошин зурхай, хөрөглөсөн хошин ярилцлага, хошин шүлэг, хошигнол, ёгт үлгэр, шог шүлэг, хошин ерөөл, өгүүллэг, ёгт эрэгцүүлэл, наргиа, ёргио үг, хууч яриа, хөрөг, нөхөрсөг элэглэл, элэглэл тууж, явган шог, хошин танилцах зар, хошин үгийн сүлжээ, хошин суудал, орон нутгийн «Бэлэн Сэнгээ»-ийн яриа, шог яриа (онигоо) гэх мэт 30 гаруй бичлэгийн төрөл зүйлээр бичигдэх болж баяжжээ.

Монголын хошин шог нийтлэл түүхэн хөгжлийнхөө явцад 40 гаруй бичлэгийн төрөл зүйлээр 30 гаруй сэдвийг хамран нийтлэгдэж ирсэн байна.

Мөн бичлэгийн төрөл зүйлийн тоо тогтмол олшрон нэмэгдсээр ирсэн нь тодорхой харагдана. Дээрх бичлэгийн төрөл зүйлүүдээс хошин өгүүллэг, шог өгүүллэг, шог найруулал, шог яриа (онигоо), егөөдөл, өгүүллэг зэрэг бичлэгийн зүйл сүүлийн үеийн «Тоншуул» сэтгүүлийн нэг дугаарт 2-5 хүртэл орсон байгаа нь эдгээр бичлэгийн зүйл бусад зүйлээс харьцангуй олноор нийтлэгдэж байгааг харуулж байна. «Матар» сэтгүүлийн үеийн хамгийн түгээмэл бичлэгийн зүйл шог өгүүлэл, «Хүмүүжил жигшил» сэтгүүлийнх мөн л шог өгүүлэл байгаа бол орчин үеийн «Тоншуул» сэтгүүлийн хувьд хошин өгүүллэг, шог

өгүүлэг, шог найруулал, шог яриа (онигоо), нөхөрсөг элэглэл, хошин мэдээ, хөрөглөсөн хошин ярилцлага байна.

«Матар», «Хүмүүжил жигшил» сэтгүүлүүдийн үеийн манай хошин шог нийтлэл нь 10 гаруй төрөл зүйлээр тогтмол бичигдэж байсан бол энэ үеийн «Тоншуул» сэтгүүлийн хошин шог нийтлэл нь 30 орчим төрөл зүйлээр нийтлэгдэх болжээ.

Нэг онцлог зүйл ажиглагдаж байгаа нь «Матар», «Хүмүүжил жигшил» сэтгүүлүүдийн үед нийтлэгдэж байсан шог өгүүлэл, хошин зүйр үг, шог үзэгдэл, ардын шог үг, шог үлгэр, хошин оньсого, шог дуу, үлгэр зэрэг бичлэгийн зүйл орчин үеийн манай хошин шог нийтлэлд ховорхон нийтлэгдэх болжээ.

Манай хошин шог нийтлэл «Матар», «Хүмүүжил жигшил» сэтгүүлийн нийтлэлтэй харьцуулбал орчин үед тооны хувьд хоёр дахин нэмэгдсэн байна. Өөрөөр хэлбэл «Матар», «Хүмүүжил жигшил» сэтгүүлүүдэд жилд дунджаар 100 гаруй томоохон материал нийтлэгдэж байсан бол өдгөө 200 гаруй томоохон нийтлэл гарах болжээ.

1990 оноос хойшх үеийн Монголын хошин шог нийтлэлийн төлөөлөгчид бол Н.Иштавхай, Н.Даваадаш, Ц.Доржготов, И.Цэрэнжамц, Д.Баясгалан, Г.Жамъяндорж, Л.Ожгоош, Г.Рагчаа, Ж.Барамсай, Н.Пүрэвсүрэн, М.Гүрсэд, Б.Ханд, А.Амарсайхан, Ц.Ганбаатар, Шаг.Цэнд-

«

*Монголын хошин шог нийтлэл түүхэн хөгжлийнхөө явцад 40 гаруй бичлэгийн төрөл зүйлээр 30 гаруй сэдвийг хамран нийтлэгдэж ирсэн байна. Мөн бичлэгийн төрөл зүйлийн тоо тогтмол олшрон нэмэгдсээр ирсэн нь тодорхой харагдана.*

»



Аюуш, Д.Жаргалсайхан, Б.Батчимэг, С.Баярхүү, З.Ганболд, Ж.Отгонцагаан, Ц.Нацагдорж, Ш.Бадамханд, Ю.Санжаагончиг, Ж.Лхагва, Б.Цэнддоо нар юм.

1990 оноос хойш энэ үеийн «Тоншуул» сэтгүүлд улс төрийн тогтолцооны согог, цэнгээний газрууд, албан ажил цалгардуулдаг албан тушаалтан, завхай явдалтан, архичид, хүн чанараа гээгчид, баяр цэнгэл хөөгчид, зурхайчид, цагдаа нарыг шоглосон, байгал эхээ сүйтгэгчид, ардчилал, шударга ёс, хүний эрхийг зөрчигчид, авлига, хээл хахууль авагчид, хэл ярианы соёл алдагдуулагчдыг шүүмжилсэн, нийгмийн эмзэг бүлгийнхнийг хошигносон нийтлэл олноор нийтлэгдэх болжээ.

**Х**арин эдгээр сэдвээр бичигдсэн хошин шог нийтлэл «Матар», «Хүмүүжил жигшил» сэтгүүлд бараг байгаагүй байна. Ер нь ганц хоёр сэдэв л Монголын хошин шог нийтлэлийн аль ч үеийн хэвлэлд тусч иржээ. Тухайлбал: албан ажил шалгардуулдаг, хариуцлагагүй албан тушаалтныг шоглосон нийтлэл Монголын аль ч үеийн хошин шог хэвлэлд тусч ирсэн байна. Харин завшигчид, залилан мэхлэгч луйварчид, хөдөлмөрийн шинэ хүний алдаа төөрөгдөл, шинэ цагийн хөгжилд саад бологч, нийгмийн хөгжлөөс хоцрогчид зэрэг сэдвээр бичигдсэн нийтлэл «Матар», «Хүмүүжил жигшил» сэтгүүлд; архичид, хулгайчид, завхай явдалтнууд зэрэг сэдвээр бичигдсэн нийтлэл «Матар», «Тоншуул» сэтгүүлд; гэр бүлийн хүчирхийлэгчид, хүн чанараа гээгчид, баяр цэнгэл хөөгчид зэрэг сэдвээр бичигдсэн нийтлэл «Хүмүүжил

жигшил», «Тоншуул» сэтгүүлд тус тус түлхүү нийтлэгдэж иржээ.

### Ишлэл

<sup>1</sup> Г ү н д а л а й Ш. 2005. Монгол шог хошин өгүүллэг. УБ.

<sup>2</sup> Н о р о в с ү р э н Л. 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Тэргүүн боть. УБ., 127 дахь тал.

<sup>3</sup> Мөн тэнд, 130 дахь тал.

<sup>4</sup> Н о р о в с ү р э н Л. 2008. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйл. УБ., 261 дэх тал.

### Ном зүй

1. Д а р ж а а Д. 1951. Шүүмжлэл, өөрийн шүүмжлэлийн нэн хурц хэлбэр бол инээдэмт шог зохиол, шог зураг. «Үнэн» сонин. №60.

2. Д а р ж а а Д. 1969. Шог хошин зохиол. «Утга зохиол урлаг» сонин. №37.

3. Б а а с т Б. 1964. Өөлөх үү? Шоолох уу? «Урлаг утга зохиол» сонин. №50.

4. В а н г а н Л. 1967. Шог зохиолын дайчин чанар. «Үнэн» сонин. №25.

5. Г а а д а м б а Ш. 1964. Шогловол хаширтал, шилбүүрдвэл хорстол. «Урлаг утга зохиол» сонин. №30.

6. Г а а д а м б а Ш. 1967. Шог найруулал бичих тухай. «Үнэн» сонин. №25.

7. Л у в с а н в а н д а н С. 1973. Шог зохиолын учир. «Монголын орчин үеийн уран зохиолын онол түүхийн асуудалд». УБ.,

8. Л у в с а н в а н д а н С. 1964. Шог зохиолыг элбэгжүүлэе. «Соёл, утга зохиол» сонин. №29.

9. С о д о в Л. Шог зохиол, шог найрууллын тухай. 1965. «Утга зохиол урлаг» сонин. №10.

10. Ж и г м э д г о т о в О. 1969. Шог найруулал. «Хөдөлмөр» сонин. №76.

11. С э н г э э Д. 1955. Шог найрууллын тухай. Ховд аймгийн «Хөдөлмөр» сонин. №34.

12. Ц э е н ж а в Н. 1965. Шог хошин зохиолыг анхаарах цаг болжээ. «Утга зохиол урлаг» сонин. №10.

13. Х а с б а а т а р Ц. 1989. Шог хошин зохиолын тухай. «Уран зохиолын тухай тэмдэглэл». УБ.

14. Ө л з и й б а я р Д. 1988. Монголын орчин үеийн шог хошин зохиолын төрөл зүйлийн тухай. «Цог» сэтгүүл. №5.

15. Ц э н д – А ю у ш Ши. 1988. Далаад оны инээдмийн зохиол. «Уран зохиолын шүүмжлэлийн тухайд». УБ.

16. Н а р а н т у я а Р. 1995. Далан худалчийн үлгэр нийгэм улс төрийн шог хошин өнгө аясыг олсон нь. «Аман зохиол судлал». УБ.

17. Н о р о в с ү р э н Л. 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Тэргүүн боть. УБ.

18. Н о р о в с ү р э н Л. 2008. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл. УБ.

### Резюме

В данной статье автор описывает специфику публикаций журнала "Матар"

("Крокодил"), который сыграл ключевую роль в развитии и становлении монгольской юмористической и сатирической прессы.

Пионером в этой области являлся журнал "Хумуужил жигшил" ("Воспитание и презрение"), выходивший в 1935-1942 гг. "Матар", ставший его преемником, выступал как рупор социалистического воспитания и идеолог коммунистического самосознания. Главной тематикой журнала "Матар" являлись такие злободневные недостатки, как халатность, бюрократизм, пьянство, лень, потеря стыда, пренебрежительное отношение к труду, к своей обязанности.

В данной статье рассматриваются основная тематика и специфика творчества отечественных журналистов, специализирующихся по юмористическим и сатирическим жанрам и работавших в журнале "Тоншуул" ("Дятел") в постсоциалистический период.